



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/115

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг
чадавхжуулах сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7, 24 дүгээр зүйлийн 24.1, 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор Дэлгэрхаан, Батширээт, Биндэр, Дадал, Норовлин сумдын ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл өндөртэй алслагдсан газар амьдарч буй малчин иргэдийг түшиглэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулсугай.

2.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 24 дүгээр “Журам батлах тухай” тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар” зэргийг баримталж байгуулахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг сургаж бэлтгэх, багаж хэрэгслээр хангах ажлыг Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүн, “Ногоон ой эрсдэлгүй орчин” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын тэргүүн (Т.Чулуунбаатар)-д үүрэг болгосугай.

4.Гамшигтай тэмцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах сайн дурын хэсгүүдэд олгосон багаж хэрэгслийг байршуулах агуулахын зориулалттай байр байгуулж, хадгалалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



